



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/132/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.dornogovi.audit.mn Сайншанд хот 2020 он	Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Аудитын менежер: Э.Энхцэцэг Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn Аудитор: О.Нарангарав Утас: 70523020 Цахим хаяг: Narangarav.o@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3. Менежментийн захидал	11
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18

Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2020.02.06 № 1-6/18
танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
САЙНШАНД ДАХЬ ГААЛИЙН
ГАЗРЫН ДАРГА О.ЦЭЭНРЭГЗЭН
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Татварын хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар нь 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

010020012

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг байгууллагын дарга О.Цэенрэгзэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 29-ээс 2020 оны 01 дугаар сарын 30-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 01 дугаар сарын 30-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор О.Нарангарав хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/19 дүгээр албан бичгээр 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр ирүүлсэн байна. Аудитаар залруулгын бүртгэл хийгдэж залруулсан тайланг 2020 оны 02 дугаар сарын 03 өдөр 1/29 дүгээр албан бичгээр ирүүлсэн болно.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд оршино”-д оршино.

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гаалийн байгууллага хоорондын хамтын үйл ажиллагааг идэвхжүүлэх
- Хууль бус худалдаатай тэмцэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шаардлагатай дүрэм журмыг боловсруулах, хэрэгжилтийг хангах
- Гаалийн байгууллагын хүний нөөцийн цогц бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх
- Гаалийн лабораторийг бэхжүүлэх, үйл ажиллагааг өргөтгөх
- Гаалийн зөрчлийн мэдээллийн нэгдсэн санг боловсронгуй болгох, гаалийн зөрчлийн талаар мэдээлэл солилцох, тандалт судалгаа явуулах

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Юникус” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас

жилийн санхүүгийн тайлангийн цэвэр хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,485572.2 мянган төгрөгөөс тооцон 14,855.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 9,223.5 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн үе шатанд тооцсон материаллаг байдлыг 2019 оны эхний хагас жилийн үзүүлэлтээр тооцсон, мөн гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг нарийвчлан авч үзэх шаардлагатай гэж үзэж хамгийн бага үзүүлэлт болох нийт зардлыг сонгон авч түүний 1 хувиар тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,576,912.0 мянган төгрөгөөр буюу 121.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага 681.1 мянга, бараа материал 18,603.1 мянга, үндсэн хөрөнгө 1,557,627.8 мянга, өр төлбөр 9,628.3 мянга, цэвэр хөрөнгө өмчийн дүн 1,567912.0 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Зөрүү	
				Дүн	Хувь
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	45,962.89	65,247.09	19,284.19	41.96
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-	-	-
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-	-	-
33	АВЛАГА	115.76	796.83	681.08	588.37
34	УРЬДЧИЛГАА	-	-	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	45,847.14	64,450.25	18,603.11	40.58
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,256,381.23	2,813,359.06	1,556,977.82	123.93
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,256,381.23	2,813,359.06	1,556,977.82	123.93
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,302,344.13	2,878,606.14	1,576,262.01	121.03
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	9,628.27	9,628.27	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	9,628.27	9,628.27	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,302,344.13	2,868,977.87	1,566,633.74	120.29
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,302,344.13	2,878,606.14	1,576,262.01	121.03

Авлага дансны үлдэгдэл нь оны эцэст авлага 681.1 мянган төгрөгөөр өссөн нь ажилчдаас 522.1 мянган төгрөгийн, хоорондын тооцоогоор түлш халаалтын 159.0 мянган төгрөгийн авлага үүссэн нь шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2018 онд үүссэн 115.8 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 18,603.1 мянган төгрөгөөр өссөн нь бэлэн бүтээгдэхүүн 7,235.5 мянга, бичиг хэрэг, цэвэрлэгээний материал 139.9 мянга, аж ахуйн материал 5,340.9 мянга, түлш шатах тослох материал 2,372.8 мянга, мал амьтанд 5,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, сэлбэг хэрэгсэл, бусад хангамжийн материал 1,485.9 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна. Салбар хоорондын дотоод тооцоогоор 5000.0 мянган төгрөгийн 300 толгой малыг, мөн ГЕГ-аас хяналт шалгалтын хэрэгцээнд ашиглагдах 11,942.2 мянган төгрөгийн материалыг шилжүүлэн авч бүртгэсэн нь бараа материал өсөхөд голлон нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь барилга байгууламж 1,239,234.0 мянга, авто тээврийн хэрэгсэл 209,500.0 мянга, тавилга эд хогшил 41,514.5 мянга, дуусаагүй барилга 204,774.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, машин тоног төхөөрөмж 21,727.1 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Тайлант онд салбарын хөрөнгө оруулалтаар “Гаалийн шинэчлэл” төслийн хүрээнд 1,172,472.0 мянган төгрөгийн гаалийн лабораторийн барилгыг шинээр барьж, 129,965.4 мянган төгрөгийн дуусаагүй барилга, 163,500.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 46,068.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 12,856.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг, мөн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Ханги боомтод 72,480.7 мянган төгрөгийн гэрэлтүүлэг, 46,000.0 мянган төгрөгийн бохир соруулах тээврийн хэрэгслийг өгснийг үндсэн хөрөнгийн холбогдох дансанд тус тус нэмж бүртгэсэн байна.

ГЕГ-ын 2019 оны А/254 дугаар тушаалаар 78,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг балансаас балансад шилжүүлэн, ГЕГ-ын 2019 оны А/304, А/311 дугаар тушаалаар 7,114.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлан данс бүртгэлээс хассан байна.

Биет бус хөрөнгөнд 66.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал нэмэгдэж үлдэгдэл 66.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд нийт 83,088.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал, балансаас балансад шилжиж ирсэн тээврийн хэрэгслийн 52,746.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл тус тус нэмэгдэж, актлагдсан хөрөнгийн 28,867.3 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг бүртгэлээс хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 9,628.3 мянган төгрөгөөр өссөн нь нэг албан хаагчийн бодогдсон цалинг НД-ийн тайланд тайлагнаагүйгээс 358.3 мянган төгрөгийн НДШ-ийн өглөг үүссэн, мөн нүүрс татан авч мөнгийг шилжүүлээгүйгээс 9,260.0 мянган төгрөгийн өглөг үүссэн нь шалтгаалжээ. Өглөгийг тооцоог харилцагч байгууллагуудтай нийлж баталгаажуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,868,977.9 мянган төгрөг болж 1,566,633.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь шалтгаалжээ. Энэ нь тайлант онд хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө, бараа материал нэмэгдсэнийг илэрхийлж байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар тайлант онд 540.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 2,745.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 5 дахин давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Улсын төсвөөс санхүүжих	951,617,500.00	951,617,500.00	-	100.00
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	540,000.00	2,745,000.00	2,205,000.00	508.33
Нийт дүн	952,157,500.00	954,362,500.00	2,205,000.00	100.30

Туслах үйл ажиллагааны орлого 2,205.0 мянган төгрөгөөр давсан нь түрээсийн цэвэр орлого 2,646.0 мянган төгрөг, тендерийн бичиг баримтын орлого 99.0 мянган төгрөг төвлөрсөнтэй холбоотой байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 952,157.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 952,157.5 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 951,617.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 540.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Улсын төсвөөс 951,617.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны цэвэр орлого 2,745.0 мянган төгрөг нийт 954,362.5 мянган төгрөгийн санхүүжилттэй ажилласан байна.

Тайлант оны түрээсийн нийт орлого 3,780.0 мянган төгрөгөөс 1,134.0 мянган төгрөгийг ТӨХ-д төвлөрүүлж цэвэр орлого 2,646.0 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 931,452.6 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байна. Үүний: Албан хаагчдын цалин, НДШ-ийн зардал 637,096.2 мянган төгрөг нь нийт зардлын 68.4 хувь, бараа ажил үйлчилгээний бусад зардал 179,288.8 мянган төгрөг нь нийт зардлын 19.3 хувь, биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал 115,067.6 мянган төгрөг нь нийт зардлын 12.3 хувийг тус тус эзэлж байна.

Жилийн эцэст давсан орлогын 2,205.0 мянга, урсгал зардлын хэмнэлт 20,704.9 мянган төгрөг нийт 22,909.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 8 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 12,035.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 5,069.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,242.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 5,724.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 6,966.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 6,966.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой

Үйл ажиллагааны зардлаас 5,724.1 мянган төгрөгийг эдийн засгийн ангилал зөрчин зарцуулсан байна. Үүнд:

- Гэрэл цахилгааны зардлаас 1,915.0 мянган төгрөгийг гэрэл цахилгааны урсгал засварын зардалд зарцуулсан

- Түлш халаалтын зардлаас 1,679.4 мянган төгрөгийг гэрэл цахилгааны төлбөр төлснийг түлш хаалтын зардалд тайлагнасан
- Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйл авах зардал болон урсгал засварын зардлаас 2,129.7 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авсан

Энэ нь Үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна..

Шийдвэрлэсэн нь: Аудитаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

2. Зардлын данстай холбоотой

Томилолтын зардлыг олгох зөвшөөрөлгүй, сунгалт хийгдээгүй, хүчин төгөлдөр бус томилолтын хуудсаар 2 албан хаагчид 1,242.0 мянган төгрөгийн томилолтыг бодож олгосон байна.

Энэ нь Үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 6-р тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 2 дахь зүйл заалтыг тус тус зөрчсөн байна..

Шийдвэрлэсэн нь: Аудитаар төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно..

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 142 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 163.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосноос 163.7 мянган төгрөгийг бүрэн барагдуулсан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. **Балансын данстай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт: Бараа материалыг нэр төрлөөр тулгаж үзэхэд бэлэн бүтээгдэхүүн дансанд аж ахуйн материал, лабораторийн эм хэрэгслийг буруу ангилан бүртгэсэн байна

Энэ нь Толилуулга ба тодруулга батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 4.17-д “ Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг мөрдөнө” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

1.3. Өгсөн зөвлөмж: Бараа материалыг ангиллын дагуу үнэн зөв бүртгэж байх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгч буй зөвлөмжид санал байхгүй гэсэн хариу тайлбарыг баталгаажуулан ирүүлсэн байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>45,962,894.86</u>	<u>65,247,086.81</u>
33	АВЛАГА	115,756.43	796,833.76
335	Бусад авлага	115,756.43	796,833.76
3352	Хувь хүмүүсээс авах авлага	115,756.43	637,843.76
35	БАРАА МАТЕРИАЛ	45,847,138.43	64,450,253.05
35300	Бэлэн бүтээгдэхүүн	22,605,153.39	29,840,617.88
354	Хангамжийн материал	23,241,985.04	29,609,635.17
35410	Бичиг хэргийн материал	4,597,580.00	4,659,447.00
35420	Аж ахуйн материал	15,201,392.14	20,542,257.17
35430	Сэлбэг хэрэгсэл	1,300,000.00	750,000.00
35440	Түлш, шатах тослох материал	828,837.90	3,201,600.00
35460	Хүнсний материал	378,275.00	456,331.00
35470	Бусад хангамжийн материал	935,900.00	-
35600	Мал амьтад	-	5,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,256,381,234.02</u>	<u>2,813,359,055.65</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,256,381,234.02	2,813,359,055.65
392	Биет хөрөнгө	886,655,234.02	2,443,699,055.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	840,448,018.60	2,079,682,047.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(165,546,778.86)	(201,238,286.25)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,736,017.00	308,236,017.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(91,802,012.84)	(163,771,196.78)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	344,722,428.90	322,995,306.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	(149,475,612.42)	(152,850,854.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,734,695.40	97,249,195.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(46,161,521.76)	(51,377,504.32)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	204,774,331.00
393	Биет бус хөрөнгө	369,726,000.00	369,660,000.00
39301	Програм хангамж	980,000.00	980,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(870,000.00)	(936,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	369,616,000.00	369,616,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,302,344,128.88</u>	<u>2,878,606,142.46</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>9,628,274.59</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	9,628,274.59
413	Өглөг	-	9,628,274.59
4136	Бусад өглөг	-	9,628,274.59
41361	Байгууллагад төлөх өглөг	-	9,628,274.59
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,302,344,128.88</u>	<u>2,868,977,867.87</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,302,344,128.88	2,868,977,867.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,293,630,053.34	1,293,630,053.34
51101	Өмч: - төрийн	1,293,630,053.34	1,293,630,053.34
512	Хуримтлагдсан үр дүн	(384,712,525.06)	1,182,571,213.93
51210	Өмнөх үеийн үр дүн	(384,712,525.06)	(384,712,525.06)
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,566,633,738.99
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	393,426,600.60	393,426,600.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,302,344,128.88</u>	<u>2,878,606,142.46</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөг/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	665,884,340.00	2,551,900,280.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,392,940.00	1,600,282,780.60
120	Нийтлэг татварын бус орлого	17,392,940.00	1,600,282,780.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	99,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		99,000.00
120005	Түрээсийн орлого	3,402,000.00	2,646,000.00
120009	Бусад орлого	13,990,940.00	1,597,537,780.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	648,491,400.00	951,617,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	648,491,400.00	951,617,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	648,491,400.00	951,617,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	723,772,910.99	924,560,097.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	723,772,910.99	924,560,097.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	708,711,146.97	901,650,234.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	470,608,368.19	565,932,539.76
210101	Үндсэн цалин	462,028,368.19	550,364,539.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,580,000.00	15,568,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,447,466.36	71,009,847.95
210201	Тэтгэврийн даатгал	56,447,466.36	52,576,718.78
210202	Тэтгэмжийн даатгал	-	3,729,241.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	4,577,789.34
210204	Ажилгүйдлийн даатгал	-	970,519.65
210205	Эрүүл мэндийн даатгал	-	9,155,579.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,668,500.10	54,813,210.97
210301	Гэрэл, цахилгаан	17,454,500.00	18,304,800.07
210302	Түлш, халаалт	35,219,800.10	32,552,067.90
210303	Цэвэр, бохир ус	3,994,200.00	3,956,343.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,818,394.31	29,574,734.40
210401	Бичиг хэрэг	4,259,480.00	7,978,391.00
210402	Тээвэр, шатахуун	7,741,000.00	15,540,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	809,139.00	822,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	172,255.00	953,258.67
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,836,520.31	2,412,462.33
210408	Бараа материал акталсны зардал		1,867,522.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,522,820.00	82,177,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	636,820.00	810,970.00
210604	Урсгал засвар	35,886,000.00	81,366,330.00
2107	Томилолт, зочны зардал	1,654,000.00	1,449,000.00
210702	Дотоод албан томилолт	1,654,000.00	1,449,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,307,780.96	13,529,852.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,261,711.04	5,500,335.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,793,700.00	1,920,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,718.00	136,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	100,896.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	173,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	13,051,651.92	5,699,121.52
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,683,817.05	83,163,748.49
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	75,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,383,817.05	83,088,748.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,061,764.02	22,909,863.48
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,061,764.02	22,909,863.48
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,061,764.02	22,909,863.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(57,888,570.99)</u>	<u>1,627,340,183.03</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	60,706,444.04
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	60,706,444.04
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(60,706,444.04)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(57,888,570.99)</u>	<u>1,566,633,738.99</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>661,858,929.00</u>	<u>957,040,798.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,860,000.00	3,879,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,860,000.00	3,879,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	99,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	99,000.00
120005	Түрээсийн орлого	4,860,000.00	3,780,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	656,998,929.00	953,161,798.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	648,491,400.00	951,617,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	648,491,400.00	951,617,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,507,529.00	1,544,298.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,507,529.00	1,544,298.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>661,858,929.00</u>	<u>841,973,143.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	661,858,929.00	841,973,143.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	642,717,635.98	816,384,981.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	470,724,124.62	566,348,488.52
210101	Үндсэн цалин	314,782,662.61	371,926,900.00
210102	Нэмэгдэл	92,605,425.01	115,158,636.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,051,000.00	16,864,100.00
210104	Урамшуулал	53,285,037.00	62,398,851.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,447,466.36	70,747,711.93
210201	Тэтгэврийн даатгал	41,031,099.99	53,330,311.93
210202	Тэтгэмжийн даатгал	3,630,566.37	4,353,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,773,000.00	3,336,740.60
210204	Ажилгүйдлийн даатгал	693,000.00	1,018,159.40
210205	Эрүүл мэндийн даатгал	8,319,800.00	8,708,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,719,338.00	49,999,963.07
210301	Гэрэл, цахилгаан	17,454,500.00	18,540,375.07
210302	Түлш, халаалт	33,270,638.00	27,465,388.00
210303	Цэвэр, бохир ус	3,994,200.00	3,994,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,010,121.00	22,980,400.00
210401	Бичиг хэрэг	900,000.00	4,500,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,740,600.00	15,540,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	859,539.00	822,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	167,200.00	682,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	342,782.00	1,434,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,933,100.00	83,881,611.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,426,400.00	1,606,406.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	620,700.00	1,084,205.00

210604	Урсгал засвар	35,886,000.00	81,191,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,654,000.00	1,449,000.00
210702	Дотоод албан томилолт	1,654,000.00	1,449,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,929,486.00	20,902,807.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,916,900.00	14,545,735.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,793,700.00	1,920,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136,000.00	136,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	64,718.00	120,896.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	183,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,990,168.00	3,996,676.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	75,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	75,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,141,293.02	25,588,161.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,507,529.00	1,544,298.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,507,529.00	1,544,298.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,175,764.02	22,909,863.48
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,061,764.02	22,909,863.48
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,458,000.00	1,134,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,458,000.00	1,134,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	===== -	<u>115,067,655.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	115,067,655.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	115,067,655.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	115,067,655.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		115,067,655.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	===== -	<u>(115,067,655.00)</u>

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,293,630,053.34	393,426,600.60	-384,712,525.06	1,302,344,128.88
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,293,630,053.34	393,426,600.60	-384,712,525.06	1,302,344,128.88
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,566,633,738.99	1,566,633,738.99
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,293,630,053.34	393,426,600.60	1,181,921,213.93	2,868,977,867.87

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	952,157,500.00	931,452,636.52	20,704,863.48	97.83
УРСГАЛ ЗАРДАЛ	952,157,500.00	931,452,636.52	20,704,863.48	97.83
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	952,157,500.00	931,452,636.52	20,704,863.48	97.83
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	569,922,400.00	566,348,488.52	3,573,911.48	99.37
Үндсэн цалин	371,926,900.00	371,926,900.00	-	100.00
Нэмэгдэл	117,000,000.00	115,158,636.85	1,841,363.15	98.43
Унаа хоолны хөнгөлөлт	18,595,500.00	16,864,100.00	1,731,400.00	90.69
Урамшуулал	62,400,000.00	62,398,851.67	1,148.33	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,518,300.00	70,747,711.93	3,770,588.07	94.94
Тэтгэврийн даатгал	55,518,700.00	53,330,311.93	2,188,388.07	96.06
Тэтгэмжийн даатгал	4,749,900.00	4,353,800.00	396,100.00	91.66
ҮОМШӨ-ний даатгал	3,799,900.00	3,336,740.60	463,159.40	87.81
Ажилгүйдлийн даатгал	950,000.00	1,018,159.40	(68,159.40)	107.17
Эрүүл мэндийн даатгал	9,499,800.00	8,708,700.00	791,100.00	91.67
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,940,000.00	49,999,963.07	12,940,036.93	79.44
Гэрэл, цахилгаан	28,454,500.00	18,540,375.07	9,914,124.93	65.16
Түлш, халаалт	30,491,300.00	27,465,388.00	3,025,912.00	90.08
Цэвэр, бохир ус	3,994,200.00	3,994,200.00	-	100.00
Хангамж, бараа материалын зардал	24,390,100.00	24,390,100.00	-	100.00
Бичиг хэрэг	4,500,000.00	4,500,000.00	-	100.00
Тээвэр, шатахуун	15,540,600.00	15,540,600.00	-	100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	822,500.00	822,500.00	-	100.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	682,600.00	682,600.00	-	100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,844,400.00	2,844,400.00	-	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	188,047,100.00	188,039,566.00	7,534.00	100.00
Багаж, техник, хэрэгсэл	30,926,400.00	30,925,406.00	994.00	100.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,120,700.00	1,114,195.00	6,505.00	99.42
Урсгал засвар	156,000,000.00	155,999,965.00	35.00	100.00
Томилолт, зочны зардал	1,654,000.00	1,449,000.00	205,000.00	87.61
Дотоод албан томилолт	1,654,000.00	1,449,000.00	205,000.00	87.61

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,505,100.00	30,402,807.00	102,293.00	99.66
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,080,900.00	24,045,735.00	35,165.00	99.85
Даатгалын үйлчилгээ	1,920,200.00	1,920,000.00	200.00	99.99
Тээврийн хэрэгслийн татвар	136,000.00	136,000.00	-	100.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	140,000.00	120,896.00	19,104.00	86.35
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200,000.00	183,500.00	16,500.00	91.75
Газрын төлбөр	28,000.00	-	28,000.00	-
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,000,000.00	3,996,676.00	3,324.00	99.92
Бараа үйлчилгээний бусад зардал	180,500.00	75,000.00	105,500.00	41.55
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	180,500.00	75,000.00	105,500.00	41.55
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	952,157,500.00	954,362,500.00	(2,205,000.00)	100.23
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	951,617,500.00	951,617,500.00	-	100.00
Улсын төсвөөс санхүүжих	951,617,500.00	951,617,500.00	-	100.00
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	540,000.00	2,745,000.00	(2,205,000.00)	508.33
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	540,000.00	2,745,000.00	(2,205,000.00)	508.33